



Говь-Алтай аймгийн
Статистикийн хэлтэс

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР 2017 ОНД



2017

Танилцуулгыг хянан, тохиосон:

Статистикийн хэлтсийн дарга Д.Тунгалаг

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Э.Бямбадулаи

Танилцуулгыг хэвлэлд бэлтгэсэн:

Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Г.Батзориг

Хаяг: Аймгийн ЗДТГ-н 1-р байр 108, 116 тоот

Утас:70484278, 70483442

Вэб:www.govi-altai.nso.mn

И_мэйл хаяг: govi-altai@nso.mn, stat_altai@yahoo.com

АГУУЛГА

I.	Нэр томъёоны тайлбар.....	4-6
II.	Оршил.....	7
III.	Мал тооллогын дүн.....	8
	• Малчдын соёл ахуйн үзүүлэлтүүд.....	8-10
	• Малын тоо.....	10-14
	• Хээлтэгч мал.....	14-15
	• Төл бойжилт.....	15-16
	• Том малын хорогдол.....	16-17
	• Хээл хаялт, сувайралт.....	17-20
	• Сүргийн бүтэц.....	20
IV.	Малжуулалт.....	21
V.	Шинээр гаргасан болон засварласан худ.....	22-23
VI.	Газар тариалан.....	23-26
VII.	Дүгнэлт.....	27-28

Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт

Малтай өрх. Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болгож байгаа өрхийг хэлнэ.

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 Адуу, Үхэр - 1бод.

1 тэмээ – 1.5 бод.

6 хонь – 1 бод.

8 ямаа – 1 бод.

Бог малд хонин толгойд шилжүүлсэн коэффициент:

1 тэмээ – 5 хонь

1 адуу – 7 хонь

1 үхэр – 6 хонь

1 хонь – 1 хонь

1 ямаа – 0.9 хонь

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ-4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу-3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр- 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал-тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал.

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хэлнэ.

Малын тоо толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасаж гаргана. Харьцангуй үзүүлэлтүүдийг гаргахдаа оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-р үржүүлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** төл бойжилт, **зарлага тал** нь хэрэглээний зарлага, том малын зүй бусын хорогдол болно.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100-р үржүүлнэ.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-р үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-р үржүүлнэ.

Хээлтэгч хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм:

Буур – 20-25

Азарга-12-15

Бух -35-45

Хуц ухна-25-30

Малын зүй бусын хорогдолд. Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон малын тоог, оны эхний малын тоонд харьцуулан 100-р үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бусын хорогдол, оны эцсийн малын тоог хасаж гаргана.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямаа/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг хангахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд доорхи

Хадлан өвс – 0.45

Таримал тэжээл – 0.35

Даршны ургамал – 0.25

Гар тэжээл, хужир шүү – 1.0

Үр тарианы хаягдал – 0.9

Лай – 0.4

Сүрэл – 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцагын төрлийн ургамал орох бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
 1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
 2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
 3. Шүүст тэжээл- бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд үйлдвэрийн яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай гэж хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжөөсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай гэж тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээ юм.

Хураасан талбай тухайн жилд ургацгийг хурааж авсан газрийн нийт талбайн хэмжээ юм.

Га-гийн ургац гэж талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацгийг тодорхойлохдоо 1 төрлийн ургамлын тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тэр талбайн нийт хэмжээнд харьцуулж тодорхойлно.

Нийт ургац нь тухайн жилд газар тариалангийн үйлдвэр эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

Оршил

Хөдөө аж ахуй нь манай улсын уламжлалт салбар бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний багагүй хувийг үйлдвэрлэж хүн амын хүнсний хангамж, үндэсний үйлдвэрийн түүхий эдийн гол тулгуур болж байгаагийн хувьд улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн төвшинг тодорхойлох нэг үндэс байсаар ирсэн, өнөө ч энэ ач холбогдлоо алдаагүй байна.

Энэ үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, улс орны боловсруулах үйлдвэрийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагдаж байдаг.

Манай аймгийн эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар гол байр суурь эзэлдэг.

Манай улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, энэ ч утгаараа мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай монгол улсын хуулийн 7-р зүйлийн 1 дэх заалт, монгол улсын засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу статистиктийн хэлтэс мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг аймгийн хэмжээнд явуулж үр дүнг нэгтгэн гаргадаг.

Мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэсэн энэхүү танилцуулга нь мал аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд суурь мэдээлэл нь болох юм.


АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН

САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2016 оны гүйцэтгэлээр манай аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 44.0 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж байна.

Хөдөө аж ахуйн салбар үүний дотор мал аж ахуйн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түүхий эдийг нийлүүлж боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, мал аж ахуй болон газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй , баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болдог.

ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь



2017 оны гүйцэтгэлээр манай аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 46.5 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж байгаа ба, ажиллагсадын 64,7 хувь нь энэ салбарт ажиллаж байна.

Мал тооллогын 2017 оны дүн

1.1 Малтай өрх, малчдын тоо, тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд

Малтай өрх, малчдын тоо: Аймгийн хэмжээгээр 2017 оны мал тооллогын дүнгээр мал бүхий 10.2 мянган өрх тоологдсон байна. Үүний 70.6 хувь буюу 7.2 мянган өрх нь жилийн 4 улирлын турш малаа маллаж , малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх , 29.4 хувь нь буюу 3.0 мянган өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна.

Аймгийн нийт өрхийн 43.5 хувийг малчин өрх эзэлж байна .

2017 оны мал тооллогын дүнгээр 12.9 мянган малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд малчдын насны бүлгээр авч үзвэл 33.0 хувь 16-34 насны , 54.3 хувь нь 35 наснаас тэтгэвэрт гарах насныхан, 12.6 хувь нь тэтгэвэрийн насны хүмүүс байна.

	2011	2012	2013	2014	2015	2016	2017
1. Малтай өрх	9246	9264	9395	9428	9602	9932	10180
2. Малчин өрх	6994	6644	6537	6436	6658	6903	7183
3. Малчдын тоо	13889	13311	13118	12949	13294	13691	12919
16-34 насны	5684	5191	4896	4586	4726	4634	4260
35-59 насны	6587	6792	6917	7189	7333	7741	7009
Тэтгэвэрийн насны	1618	1328	1305	1174	1235	1316	1627
насны							
4. Нийт малчдаас эмэгтэй	6391	6459	6301	6216	6268	6451	5757
5. Насны бүтэц%	100.0	100.0	100.0	100.0	100	100.0	100.0
16-34 насны	40.9	39.0	37.3	35.4	35.5	33.8	33.0
35-59 насны	47.4	51.0	52.7	55.5	55.2	56.5	54.3
Тэтгэвэрийн насны	11.6	10.0	9.9	9.1	9.3	9.6	12.6
Малчин нэг өрхөд ноогдох	196	288	340	401	439	506	529
малын тоо							


2017 онд малчин өрхийн тоо 2016 оныхтой харьцуулахад 4.0 хувиар өссөн байна .

2017 онд малчин нэг өрхөд 529 толгой мал ноогдож байгаа нь 2016 оныхоос 23 толгойгоор өссөн байна.

Малчдын нийгэм ахуйн үзүүлэлт 2017 оны мал тооллогоор нийт малчин өрхийн 86.5 хувь нь цахилгааны эх үүсвэртэй , 74.6 хувь нь телевизортой , 38.8 хувь нь радиотой , 50.2 хувь нь автомашинтой , 62.9 хувь нь мотоцикльтой , 0.7 хувь нь трактортой , 64.2 хувь нь малын хашаатай , 21.1 хувь нь худагтай гэсэн дүн гарлаа. Цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо 2017 онд 6.2 мянга болж өнгөрсөн оныхоос 83-аар буюу 1.4 хувиар, телевизортой өрхийн тоо 2016 оныхоос 48-аар буюу 0.9 хувиар, автомашинтай өрхийн тоо 206-аар буюу 6.0 хувиар өссөн байна

	Өрхийн тоо						Малчин өрхийн тоонд эзлэх хувь					
	2012	2013	2014	2015	2016	2017	2012	2013	2014	2015	2016	2017
Цахилгаан үүсгүүртэй	5575	5745	5697	6021	6128	6211	83.9	87.9	88.5	90.4	88.8	86.5
Телевизортой	4865	4991	4808	5096	5311	5359	73.2	76.4	74.7	76.5	76.9	74.6
Автомашинтай	2281	2827	3040	3013	3399	3605	34.3	43.2	47.2	45.2	49.2	50.2
Мотоцикльтой	3800	4208	4355	4271	4094	4518	57.2	64.4	67.7	64.1	59.3	62.9

Малчин өрхийн нийгэм ахуйн үзүүлэлтүүд



Цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо

	Бүгд	үүнээс			Дунд эзлэх хувь		
		нарны	Бага оврын бусад цахилгаан үүсгүүр	Төвлөрсөн систем	нарны	Бага оврын цахилгаан үүсгүүр	Төвлөрсөн систем
Цахилгаан үүсгүүртэй өрх	6211	6163	9	49	99.2	0.1	0.8

2016 онд малчин өрхийн 88.8 хувь нь цахилгаан үүсгүүртэй байсан бол 2017 онд 86.5 хувь нь цахилгаан үүсгүүртэй болж цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо 1.4 хувиар өссөн байна.

Нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 99.2 хувь нь нарны, 0.1 хувь нь бага оврын болон бусад цахилгаан үүсгүүр, 0.8 хувь төвлөрсөн системийн цахилгаан эх үүсгүүртэй байна.

Мал, тэжээвэр амьтадын тоо, бүтэц


Малын тоо 2017 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр бүх малын толгойн тоо өсч, бүгд гурван сая 801.7 мянган толгой мал тоолууллаа. Үүнд тэмээ 42.0 мянга, адуу 123.7 мянга, үхэр 85.4 мянга, хонь 1194.6 мянга, ямаа 2356.0 мянган толгой байна.

Тухайлбал нийт мал 304.2 мянгаар үүнээс тэмээ 3.4 мянгаар, адуу 16.8 мянгаар, үхэр 14.3 мянгаар, хонь 87.5, ямаа 182.1 мянгаар тус тус өслөө.

2017 онд нийт 16.2 мянган сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 18.9 хувийг эзэлж байна. Сарлагийн тоо өмнөх оныхоос 33.2 хувиар буюу 4.0 мянган толгойгоор өссөн байна.

Малын тоо , төрлөөр

	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
							%	Зөрүү
Бүгд	1911049	2223191	2578123	2922571	3497492	3801651	108.7	304159
Тэмээ	28167	30392	32760	34742	38540	41955	108.9	3415
Адуу	55028	65262	76749	88369	106843	123689	115.8	16846
Үхэр	29521	39436	49351	58822	71058	85400	120.2	14342
Хонь	578078	679050	798248	909312	1107114	1194602	107.9	87488
Ямаа	1220255	1409051	1621015	1831326	2173937	2356005	108.4	182068



Малын тоо сумдаар

Сум	2016		2017				
	Бүгд	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Есөнбулаг сум	209 610	223 744	912	9 105	6 818	74 217	132 692
Алтай сум	106 433	134 765	2 577	2 985	2 260	24 501	102 442
Баян-Уул сум	245 497	232 089	1 818	8 849	5 462	88 060	127 900
Бигэр сум	173 436	194 444	2 130	5 980	7 285	49 089	129 960
Бугат сум	150 948	178 720	1 525	4 429	2 219	57 819	112 728
Дарив сум	194 413	172 056	1 718	7 536	4 578	68 223	90 001
Дэлгэр сум	261 217	287 930	2 597	8 125	5 643	101 477	170 088
Жаргалан сум	165 991	191 599	1 081	5 310	5 346	66 551	113 311
Тайшир сум	118 192	132 154	602	4 547	3 743	48 771	74 491
Тонхил сум	240 137	269 886	521	11 395	4 819	126 282	126 869
Төгрөг сум	156 849	174 258	5 525	6 892	2 884	62 519	96 438
Халиун сум	240 824	247 833	3 774	8 418	6 697	74 648	154 296
Хөхморьт сум	153 372	160 598	3 345	11 166	5 367	53 793	86 927
Цогт сум	277 604	307 558	2 884	5 615	6 732	78 853	213 474
Цээл сум	192 292	213 628	1 684	6 864	4 817	50 158	150 105
Чандмань сум	199 180	228 507	1 377	6 245	3 327	79 653	137 905
Шарга сум	161 683	171 439	5 419	5 691	5 863	35 100	119 366
Эрдэнэ сум	249 814	280 443	2 466	4 537	1 540	54 888	217 012
	3 497 492	3 801 651	41 955	123 689	85 400	1 194 602	2 356 005

2017 оны хамгийн их мал өсөлттэй сум нь Алтай 26.6 хувьтай байна.

Малын тоо толгойн өсөлтөд гол нөлөөлсөн зүйл нь хээлтэгч малын тооны өсөлтөөр бойжсон төлийн тоо нэмэгдсэн, сувайрсан мал буурсан гол шалтгаан болжээ.

Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүд

	2012	2013	2014	2015	2016	2017	2016/2015	
							%	Зөрүү
Бойжуулсан төл	616905	706949	821438	945639	1080628	1306992	114.3	124201
Том малын зүй бусын хорогдол	34182	36804	35093	16223	35131	10900	31.0	-18870
Хээлтэгч малын тоо	784771	915793	1046907	983540	1412013	1514281	143.6	-63367
Хээл хаясан хээлтэгч	18931	18619	19453	20984	31715	14061	151.1	1531
Сувайрсан хээлтэгч	35342	50320	50143	72705	70665	92239	97.2	22562

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг авч үзвэл тэмээ 1.1, адуу 3.3, үхэр 2.2, хонь 31.4, ямаа 62.0 хувийг тус тус эзэлж байна. 2016 онтой харьцуулахад нийт мал сүрэгт хонь, ямаан сүргийн эзлэх хувийн жин 0.2-0.3 пунктээр буурч, адуу, үхэр сүрэг өссөн үзүүлэлттэй байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Тэмээ	1.9	1.6	1.5	0.9	1.3	1.9	1.1	1.1
Адуу	2.9	2.9	2.9	2.9	3.0	3.0	3.1	3.3
Үхэр	1.4	1.4	1.6	1.8	1.9	2.0	2.0	2.2
Хонь	30.1	28.6	30.2	30.5	30.9	31.1	31.6	31.4
Ямаа	63.7	65.6	63.8	63.4	62.9	62.6	62.2	62.0

2017 оны байдлаар авч үзвэл бог малын 33.6 хувийг хонь, 66.4 хувийг ямаа эзэлж байна.

2017 онд нийт малын тоогоор Цогт сум, тэмээгээр Төгрөг сум, адуугаар Тонхил, хониор Тонхил сум, үхрээр Бигэр сум, ямааны тоогоор Эрдэнэ сум аймагтаа тэргүүлж байна.

Хувийн малын тоо: 2017 онд хувийн малын тоо 3793.3 мянган толгойд хүрч нийт малын 99.8 хувийг эзэлж байна. Тэмээний 99.8 хувь, адууны 99.8, үхрийн 99.3, хонины 99.7, ямааны 99.8 хувь нь хувийн аж ахуйд байна. Хувийн малын тоо 2016 оныхоос 301.7 мянгаар өссөн үзүүлэлттэй байна.

Хувийн малтай өрхийн тоо

	Өрхийн тоо	Бүгд	Үүнээс				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2000	12581	2006582	31432	91190	59314	831938	992708
2001	11736	1696656	27976	74723	39386	683338	871233
2002	10330	1004258	22026	34918	16402	355386	575526
2003	10160	1253463	23670	40290	19720	398892	770891
2004	10106	1532401	24300	47030	24632	479879	956560
2005	10159	1825870	24844	54217	30415	584560	1131834
2006	10411	2190762	25924	62468	37356	700109	1364905
2007	10448	2478511	27262	71433	42255	772368	1565193
2008	10606	2497279	26941	73624	41801	766074	1588839
2009	10200	2165565	26813	65834	36164	691936	1344818
2010	9505	1313556	24321	38726	18340	395189	836980
2011	9246	1609839	25198	46534	21910	460582	1055615
2012	9264	1907081	28124	54951	29315	576926	1217765
2013	9395	2219192	30379	65174	39302	677788	1406549
2014	9428	2572398	32651	76618	49338	796177	1617614
2015	9602	2915840	88238	58602	34727	907007	1827266
2016	9932	3491568	38523	106679	70750	1105142	2170474
2017	10180	3793284	41853	123495	84817	1191555	2351564

2017 оны байдлаар хувийн аж ахуйн нийт малын 62.0 хувийг ямаа, 31.4 хувийг хонь, 2.2 хувийг үхэр, 3.3 хувийг адуу, 1.1 хувийг тэмээ эзэлж байна.

Малтай 10180 өрхийг малын тоогоор нь бүлэглэн авч үзвэл: 2017 онд 100 хүртэл толгой малтай өрхийн тоо 2055 болж, 2016 оныхоос 92 өрхөөр буюу 4.3 хувиар буурч, 100-гаас дээш малтай өрхийн тоо 8125 болж 2016 оныхоос 340-өөр буюу 4.5 хувиар өслөө.

2017 онд нийт малтай өрхөд 100 хүртэл толгой малтай өрхийн хувийн жин 20.2 хувь болж, 2016 оныхоос 1.4 пунктээр буурч, харин түүнээс дээшхи бүлгийн малтай өрхийн эзлэх хувийн жин 79.8 хувь болж 1.4 пунктээр өссөн байна.

2016 оны байдлаар малтай өрхийн дийлэнх хувь буюу 83.0 хувь нь 51-999 хүртэл толгой малтай байна. Уг үзүүлэлт 2016 онд 82.8 хувьтай байсан бөгөөд 0.2 пунктээр өссөн байна. Нийт малтай өрхийн 7.0 хувийг 1000-аас дээш малтай өрх эзэлж байгаа нь малчдын мал өсч байгааг харуулж байна.

Малтай өрхийн малын бүлэглэлт

Бүлэг	Малтай өрхийн тоо				Малын тоо			
	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2017
Дүн	9428	9602	9932	10180	2572398	2915840	3491568	3793284
<10	134	144	121	118	822	906	742	763
11-30	571	498	424	390	12253	10710	9 241	8 455
31-50	630	562	521	492	25982	23020	21 502	20 560
51-100	1265	1268	1 081	1055	93415	95116	81 090	78 974
101-200	2255	2114	2 027	1947	334064	314469	301 454	290 121
201-500	3176	3262	3 415	3584	1012674	1047884	1 103 929	1 174 038
501-999	1131	1334	1 697	1848	759275	894785	1 148 091	1 265 769

1000-1499	231	357	540	626	265995	407818	625 733	726 197
1500-2000	29	49	78	90	48437	82559	130 512	151 058
2001+	6	14	28	30	19481	38573	69 274	77 349

2017 онд 1000 ба түүнээс дээш малтай 746 өрх тоологдож 2016 оныхоос 100 өрхөөр өссөн байна. 1000-аас дээш малтай өрхийн тоогоор Эрдэнэ, Тонхил, Чандмань, Дэлгэр сумууд тэргүүлж байна.


Хээлтэгч мал 2017 оны эцэст нэг сая 514.3 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь өмнөх оныхоос 102.3 мянган толгойгоор өсжээ.

Төрлөөр авч үзвэл хээлтэгч малын тоо ингэ 1.3 мянга, гүү 5.5 мянга, үнээ 4.6 мянга, эм хонь 33.0 мянга, эм ямаа 57.9 мянгаар тус тус өссөн байна.

Хээлтэгч малын тоо


	2012	2013	2014	2015	2016	2017	2017/2016	
							%	Зөрүү
Бүгд	784771	915793	1046907	1184112	1412013	1514281	107.2	102268
Ингэ	8971	9870	10415	11442	12724	13997	110.0	1273
Гүү	15573	18753	22013	25757	31622	37079	117.3	5457
Үнээ	12044	15566	18776	22332	26720	31336	117.3	4616
Эм хонь	246036	288450	335694	382432	461391	494389	107.2	32998
Эм ямаа	502147	583155	660009	742149	879556	937480	106.6	57924

Хээлтэгч малын тоо



Хээлтэгч мал нийт малын 39.8 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 33.4 хувь, адуун сүргийн 30.0 хувь, үхэр сүргийн 36.7 хувь, хонин сүргийн 41.4 хувь, ямаан сүргийн 39.8 хувийг тус тус эзэлж байна.

Хээлтэгч малд эзлэх хэвийн жин



Нийт хээлтэгч малд ингэ 1.0 хувь, гүү 2.0 хувь, үнээ 2.0 хувь, эм хонь 33.0 хувь, эм ямаа 62.0 хувийг тус тус эзэлж байна.

Төл бойжилт 2017 оны байдлаар оны эхний эх малын 94.2 хувь буюу 1 сая 330.2 мянган эх мал төллөж, гарсан төлийн 97.8 хувийг буюу 1 сая 306.9 мянган төл бойжуулсан байна. Бойжсон төлийн тоо 2016 оныхоос 226.4 мянган толгойгоор өссөн байна.

Гарсан ботгоны 96.6 хувь, унаганы 96.6 хувь, тугалын 97.1 хувь, хурганы 98.2 хувь, ишигний 97.7 хувийг бойжуулсан байна.

Төл бойжилт

	Бүгд			Үүнээс:				
	2015	2016	2017	Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг
Гарсан төл	983540	1114290	1336222	27575	24187	6714	444468	833278
Бойжсон төл	945639	1080628	1306992	26646	23475	6485	436405	813981
Бойжилтын хувь	95.9	97.5	97.8	96.6	97.1	96.6	98.2	97.7

2017 онд бойжуулсан төлийн тоог өмнөх онтой харьцуулахад бараг бүх сумд 3.2-23.8 мянгаар өссөн байна.



Бойжсон төл

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	104615	581366	616905	706949	821438	945639	1080628	1306992
Ботго	2352	3479	4669	4397	5027	5274	5908	6485
Унага	1556	8788	11054	12459	14871	18241	21984	26646
Тугал	2648	6197	8865	10909	13555	15883	19515	23475
Хурга	43833	181448	195443	231817	271219	315365	361587	436405
Ишиг	54226	381454	396874	447367	5167966	590876	671634	813981

2017 онд аймгийн хэмжээнд дунджаар 100 эхээс 93 төл бойжуулсан нь өмнөх оноос өссөн байна.

100 эхээс бойжуулсан төл

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	12	87	92	90	90	90	91	93
Ботго	30	45	58	49	51	51	52	51
Унага	8	69	79	80	79	83	85	84
Тугал	18	70	88	91	87	85	87	88
Хурга	15	86	98	94	94	94	95	95
Ишиг	10	86	91	89	89	90	90	93

Том малын зүй бус хорогдол 2017 онд оны эхний нийт малын 0.3 хувьтай тэнцэх 10.9 мянган толгой мал хорогдсон нь 2016 оныхоос 24.2 мянган толгойгоор буюу 3.2 дахин буурсан байна. Нийт хорогдлын 63.6 хувийг ямаа, 30.1 хувийг хонь, 2.6 хувийг үхэр, 2.9 хувийг адуу, 0.8 хувийг тэмээ эзэлж байна.

Нийт хорогдлын 17.1 хувь буюу 1.9 мянга нь гэнэтийн аюулаар, 12.7 хувь буюу 1.4 мянга нь өвчнөөр хорогджээ.

Том малын зүй бусын хорогдол

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	115325	738235	6160	53808	34182	36804	35093	16223	35131	10900
Тэмээ	403	2400	172	438	192	257	201	246	187	87
Адуу	3162	23567	325	837	550	670	540	516	641	311
Үхэр	3028	16967	235	801	373	379	391	488	915	286
Хонь	37921	248839	2201	14340	9316	10119	8196	4764	8280	3279
Ямаа	70811	446462	3227	37392	23751	25379	25765	10209	25108	6937

Оны эхний малд зүй бусын хорогдлын эзлэх хувь

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	4.64	29.46	0.54	2.48	2.12	1.93	1.58	0.63	1.20	0.31
Тэмээ	1.47	8.89	0.62	1.63	0.76	0.91	0.66	0.75	0.54	0.23
Адуу	4.42	31.95	0.62	1.27	1.18	1.2	0.83	0.67	0.72	0.29
Үхэр	7.14	40.43	0.75	2.20	1.68	1.28	0.99	0.99	1.55	0.40
Хонь	4.89	32.35	0.58	2.07	2.02	1.75	1.21	0.60	0.91	0.30
Ямаа	4.51	28.01	0.51	2.77	2.24	2.08	1.83	0.63	1.37	0.32

2017 онд 1.9 мянган толгой мал гэнэтийн аюулаар хорогдсон нь 2016 оныхоос 2.8 мянган толгойгоор буюу 40.1 хувиар буурсан байна.

Гэнэтийн аюулаар хорогдсон малын тоо

	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	17048	728722	3065	2395	3828	5150	3172	4665	1869
Тэмээ	54	2235	39	19	26	1	41	31	11
Адуу	602	23000	67	47	108	9	64	110	94
Үхэр	637	16571	53	47	44	32	104	136	91
Хонь	5535	245872	844	626	1069	1047	949	847	583
Ямаа	10270	441044	2062	1656	2581	4061	2014	3541	1090

Малын хээл хаялт, сувайралт 2017 онд оны эхний хээлтэгч малын 7.5 хувьтай тэнцэх 106.3 мянган мал хээл хаяж, сувайрсны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаяж, сувайрсан хээлтэгч малын тоо 2016 оныхоос 3.8 хувиар буюу 3.9 мянгаар нэмэгдсэн байна.

Төл өгөөгүй хээлтэгч малын 13.2 хувь буюу 14.1 мянга нь хээл хаясан, 86.8 хувь буюу 92.2 мянга нь сувайрсан эх мал байна.

Хээл хаяж сувайрсан эх малын тоо

	Сувайрсан					Хээл хаясан				
	2013	2014	2015	2016	2017	2013	2014	2015	2016	2017
Бүгд	50320	50143	72705	70665	92239	18619	19453	20984	31715	14061
Ингэ	190	144	401	241	231	15	6	15	49	24
Гүү	2625	2906	3214	3409	4582	347	416	549	645	516
Үнээ	1489	2111	2662	2674	3378	97	188	242	463	316
Эм хонь	15074	14496	20103	22200	28878	2918	2364	2639	4198	2225
Эм ямаа	30942	30486	46325	42141	55170	15242	16479	17539	26360	10980

Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь

	Сувайрсан					Хээл хаясан				
	2013	2014	2015	2016	2017	2013	2014	2015	2016	2017
Бүгд	6.4	5.5	6.9	6.0	1.0	2.4	5.5	2.0	2.7	6.5
Ингэ	2.1	1.5	3.8	2.1	0.2	0.17	1.5	0.1	0.4	1.8
Гүү	16.9	15.5	14.6	13.2	1.6	2.2	15.5	2.5	2.5	14.5
Үнээ	12.36	13.6	14.3	12.0	1.2	0.8	13.6	1.3	2.1	12.6
Эм хонь	6.1	5.0	5.9	5.8	0.5	1.18	5.0	0.8	1.1	6.3
Эм ямаа	6.2	5.2	7.0	5.7	1.2	3.0	5.2	2.7	3.6	6.3

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо 2017 онд 23.4 мянган толгой хээлтүүлэгч тоологдож 2016 оныхоос 92 толгойгоор буюу 0.4 хувиар өссөн байна.

Хээлтүүлэгч малын тоо

	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	14539	9045	12607	14939	16949	19120	21468	23315	23407
Буур	319	297	338	360	365	410	448	469	468
Азарга	3005	2128	2379	2574	2923	3325	3804	4413	4942
Бух	733	326	491	597	832	1057	1243	1401	1539
Хуц	4291	2583	3838	4555	5068	5657	6451	6793	6495
Ухна	6191	3711	5561	6853	7761	8680	9522	10239	9963

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохиргоо нь бод малын хувьд үржлийн нормоор харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна.

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ноогдох ёстой атал 2017 онд аймгийн дунджаар 76 эм хонь, 94 эм ямаа ноогдож 2.5 дахин өндөр үзүүлэлт гарч байна.

	Үржлийн норм	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2016
Ингэ	20-25	25	26	24	22	27	26	26	27	29
Гүү	12-15	7	6	6	5	6	7	7	7	7
Үнээ	35-45	20	27	20	17	19	18	18	19	20
Эм хонь	25-30	69	81	52	44	57	59	59	68	76
Эм ямаа	25-30	92	120	78	63	75	76	78	86	94

Малын хэрэглээний зарлага 2017 онд оны эхний нийт малын 28.4 хувьтай тэнцэх 991.9 мянган малыг хэрэглээнд зарцуулсан байна. Малын хэрэглээний зарлага өмнөх оныхоос 521.4 мянган толгойгоор өссөн байна.

Малтай нэг өрх дунджаар 97 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулжээ. Үүнийг аймгийн нийт өрхөд харьцуулбал нэг өрхөд дунджаар 60 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	229715	232211	285217	357965	433205	476539	470576	991933
Тэмээ	2144	2240	1552	1915	2462	2921	1923	2983
адуу	142	2368	2036	1556	4026	7786	2869	9489
Үхэр	1682	1856	1081	615	3855	7339	6364	8847
Хонь	101691	101691	69815	120709	143825	169749	155505	345638
Ямаа	124056	124056	210733	233140	279037	288744	303915	624976
Оны эхний малд эзлэх хувь								
Бүгд	17.5	17.7	17.6	18.7	19.5	16.3	16.1	28.4
Тэмээ	8.8	9.2	6.1	6.8	8.1	8.4	5.5	7.7
Адуу	0.4	6.1	4.4	2.8	6.2	8.8	3.2	8.9
Үхэр	9.2	10.1	4.9	2.1	9.8	12.5	10.8	12.5
Хонь	25.7	25.7	15.1	20.9	21.2	18.7	17.1	31.2
Ямаа	14.8	14.8	19.9	19.1	19.8	15.8	16.6	28.7

Оны эхний тэмээний 7.7 хувь, адууны 8.9 хувь, үхрийн 12.5 хувь, хонины 31.2 хувь, ямааны 28.7 хувийг тус тус хэрэглээнд зарцуулсан байна.

Хэрэглээнд зарцуулсан малын 97.9 хувийг бог мал 2.1 хувийг бод мал эзэлж байна.

Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод

Хэрэглэсэн малын тоо

	Зах зээлд худалдан борлуулсан				Аж ахуйн дотоодод хэрэглэсэн			
	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2017
Бүгд	172471	207538	206282	636215	154638	180914	180171	226893
Тэмээ	1263	1256	999	2792	675	775	673	716
Адуу	2484	3167	3240	10431	1559	2090	1983	2685
Үхэр	2035	3129	4060	8932	1818	2409	2671	3329
Хонь	58364	72554	73718	218048	60659	71404	71596	91975
Ямаа	108325	127432	206282	396012	89927	104236	103248	128188

Хэрэглээнд зарцуулсан малын 64.1 хувийг зах зээлд худалдан борлуулжээ.

Малтай нэг өрх дунджаар 63 толгой малыг зах зээлд борлуулж, 22 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

Сүргийн бүтэц 2017 оны байдлаар 30.5 хувь буюу 1 сая 158.3 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 29.1 хувь буюу нэг сая 105.7 мян.толгой нь нас гүйцсэн мал, 39.8 хувь буюу 1 сая 514.3 мян.толгой нь хээлтэгч мал, 0.6 хувь буюу 23.4 мян.толгой нь хээлтүүлэгч мал байна.

2017 оны сүргийн бүтэц

	Толгойгоор					Хувиар				
	Бүгд	Төл,өс вөр насны мал	Нас гүйцсэн эр мал	Хээл- тэгч	Хээл- түү- лэгч	бүгд	Төл,өс вөр насны мал	Нас гүйц- сэн эр мал	Хээл- тэгч	Хээл- түү- лэгч
Бүгд	3801651	1158260	1105703	1514281	23407	100.0	30.5	29.1	39.8	0.6
Тэмээ	41955	15433	12057	13997	468	100.0	36.8	28.7	33.4	1.1
Адуу	123689	45331	36337	37079	4942	100.0	36.6	29.4	30.0	4.0
Үхэр	85400	37701	14824	31336	1539	100.0	44.1	17.4	36.7	1.8
Хонь	1194602	382953	310765	494389	6495	100.0	32.1	26.0	41.4	0.5
Ямаа	2356005	676842	731720	937480	9963	100.0	28.7	31.1	39.8	0.4

2017 онд өмнөх оноос төл, өсвөр насны сүрэгт эзлэх хувь 1.1 хувиар өсч, нас гүйцсэн эр малын сүрэгт эзлэх хувь 0.4 хувиар, хээлтэгч малын сүрэгт эзлэх хувь 0.6 хувиар тус тус буурсан байна.

Сүргийн бүтэц,хувиар

	Төл өсвөр насны					Нас гүйцсэн эр мал				
	2013	2014	2015	2016	2017	2013	2014	2015	2016	2017
Бүгд	30.6	30.7	29.5	29.4	30.5	27.4	27.9	29.2	29.5	29.1
Ингэ	34.8	37.5	37.2	37.2	36.8	31.5	29.5	28.6	28.6	28.7
Гүү	32.9	34.9	35.4	35.9	36.6	33.9	32.1	31.1	30.4	29.4
Үнээ	45.5	44.9	43.2	43.2	44.1	12.9	15.2	16.7	17.3	17.4
Эм хонь	32.4	32.6	31.5	31.5	32.1	24.4	24.6	25.8	26.2	26.0
Эм ямаа	29.2	29.0	27.7	27.4	28.7	28.9	29.7	31.2	31.6	31.1
Үргэлжлэл										
	Хээлтэгч					Хээлтүүлэгч				
	2013	2014	2015	2016	2017	2013	2014	2015	2016	2017
Бүгд	41.2	40.6	40.5	40.4	39.8	0.8	0.7	0.7	0.7	0.6
Ингэ	32.5	31.8	32.9	33.0	33.4	1.2	1.2	1.3	1.2	1.1
Гүү	28.7	28.7	29.1	29.6	30.0	4.5	4.3	4.3	4.1	4.0
Үнээ	39.5	15.2	38	37.6	36.7	2.1	2.1	2.1	2.0	1.8
Эм хонь	42.5	42.1	42.1	41.7	41.4	0.7	0.7	0.7	0.6	0.5
Эм ямаа	41.4	40.7	40.5	40.5	39.8	0.6	0.5	0.5	0.5	0.4

Малжуулах арга хэмжээний талаарх мэдээлэл

Малжуулах арга хэмжээ нь орон нутаг, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага зэрэг олон төрлийн байгууллагын санхүүжилтээр хийгдэж байна.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийн тоо, ам бүл

	Малжуулах арга хэмжээнд хамрагдсан								1 өрхийн ам бүлийн тоо			
	Өрхийн тоо				Ам бүлийн тоо							
	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2017
Дүн	336	342	758	202	1539	1455	3094	791	4	4	5	4

2017 оны байдлаар аймгийн хэмжээнд 202 өрх малжуулах арга хэмжээнд хамрагдсан бөгөөд нэг өрхийн ам бүлийн тоо дунджаар 4 байна.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийн тоо өмнөх оныхоос 556 өрхөөр буюу 73.3 хувиар буурчээ.

	Малжуулах арга хэмжээгээр олгосон малын тоо			Үүнээс						Малжуулах арга хэмжээнд хамрагдсан 1 өрхөд ногдох малын тоо		
	2015	2016	2017	Бод малын тоо			Бог малын тоо			2015	2016	2017
Дүн	12581	30574	13075	594	676	82	11987	29898	12993	37	40	64

Малжуулах арга хэмжээгээр 202 өрхөд нийт 13.1 мянган толгой мал олгогдсон бөгөөд олгосон малын 99.4 хувь нь бог мал, 0.6 хувь нь бод мал байна. Нэг өрхөд дунджаар 64 толгой мал ноогдож байна.

Малжуулах арга хэмжээнд зарцуулсан мөнгө

	Нийт зарцуулсан хөрөнгийн хэмжээ, бүгд (мян.төг)			Үүнээс			Нийт зарцуулсан хөрөнгөд эзлэх хувь		
	2015	2016	2017	Гадаад орон, улсын хөтөлбөрийн хөрөнгөөр (сая.төг)	Орон нутгийн хөрөнгөөр (сая.төг)	Бусад(сая төг)	Гадаад орон, улсын хөтөлбөрийн хөрөнгөөр	Орон нутгийн хөрөнгөөр	Бусад
Бүгд	970.7	1916.1	524.1	49.0	239.0	236.1	9.3	45.6	45.0

2017 онд малжуулах арга хэмжээнд 524.1 сая төгрөг зарцуулсан бөгөөд үүний 9.3 хувь нь гадаад орон, олон улсын байгууллага төсөл, хөтөлбөрын хөрөнгөөр, 45.6 хувь нь орон нутгийн хөрөнгөөр, 45.0 хувь нь бусад эх үүсвэрээр санхүүжигдсэн байна.

Шинээр гаргасан, засварлагдсан худаг

Шинээр гаргасан худгийн тоо

	Шинээр гаргасан худгийн тоо, бүгд				Үүнээс:							
					Инженерийн хийцтэй				Энгийн уурхай			
	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2016
Дүн	26	30	13	22	21	22	7	14	5	8	6	8

2017 онд 22 худаг шинээр ашиглалтанд орсноос 63.6 хувь нь буюу 14 нь инженерийн, 36.4 хувь буюу 8 худаг энгийн уурхайн хийцтэй байна. Шинээр худаг гаргахад нийт 199.3 сая төгрөг зарцуулсны 72.7 хувь нь улсын хөрөнгөөр 19.8 хувь нь гадаад орон олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр 7.5 хувь нь малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр санхүүжигдсэн байна.

Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгө

	Шинээр худаг гаргахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ /мян.төг/					Үүнээс		
						Улсын төсвийн хөрөнгө өр	Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр	Малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр
	2013	2014	2015	2017	2017			
Дүн	241627.0	412850.0	8993700.0	188900.0	199300.0	144800	39500	15000

Засварлагдсан худгийн тоо

	Засварлагдсан худгийн тоо, бүгд				Үүнээс:							
					Инженерийн хийцтэй				Энгийн уурхай			
	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2017	2014	2015	2016	2016
Дүн	87	63	79	22	19	10	7	0	68	53	72	22

Худаг засварлахад зарцуулсан хөрөнгө

	Худаг засварлахад зарцуулсан хөрөнгийн хэмжээ/мян.төг/				Үүнээс		
	2014	2015	2016	2017	Улсын төсвийн хөрөнгөөр	Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр	Малчид иргэдийн өөрийн хөрөнгөөр
Дүн	150510,0	5207567.4	116329.0	20289.0	11809.0	1280.0	7200.0

Худгийн засвар шинэчлэлд 20.3 сая төгрөг зарцуулсан байна. Нийт зарцуулсан хөрөнгийн 58.2 хувь нь улсын хөрөнгөөр, 6.3 хувь нь гадаад орон,олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр, 35.5 хувь нь бусад эх үүсвэрээр буюу малчдын хамтын хөрөнгөөр санхүүжигдсэн байна.


Газар тариалан

2017 онд аймгийн хэмжээнд хаврын тариалалтаар нийт 1148.5 га талбайд үр тариа, төмс, хүнсний ногоо , тэжээлийн ургамал тариалсан ба энэ нь урд оноос төмс тариалалт 37.2 хувь буюу 32.7 га-аар,хүнсний ногоо тариалалт 30.6 хувиар буюу 27.6 га-гаар, тэжээлийн ургамал тариалалт 41.8 хувиар буюу 201.5 га-гаар тус тус өсч,үр тариа тариалалт 47.7 хувиар буюу 207.2 га-гаар тус тус буурсан байна.

ТАРИАЛСАН ТАЛБАЙ , ургамлын төрлөөр, сумаар
SOWN AREAS , by types of plants, soums

Сум	Soum	Үр тариа, га / Cereals, hectar					Төмс, га / Potatoes, hectar				
		2013	2014	2015	2016	2017	2013	2014	2015	2016	2017
Бүгд	Total	251.6	490.7	329.6	434.5	227.3	172.5	109.2	84.11	87.7	120.4
Есөнбулаг	Yesunbulag	6.5	6.6	8.3	3.7	7.5	22.3	22	23.4	25.2	21.2
Алтай	Altai		0	0	0	0.0	0.2	4.5	0.8	3.7	2.5
Баян-Уул	Bayanuul		0	0	0	0.0	0.6	1.3	0.5	1	0.2
Бигэр	Biger	10.4	4	3	3	0.7	2.7	2.4	0.36	0.7	1.3
Бугат	Bugat	3	1.9	3.5	2	0.5	14	9.2	9.2	3.5	3.0
Дарив	Darib	2.5	1	0.7	0.7	0.7	1.2	1.5	0.5	0.75	0.8
Дэлгэр	Delger	0.5	1	0.5	0	0.0	10.3	5	4.5	2.75	2.7
Жаргалан	Jargalan		2.5	0.5	1	0.0	3.7	3.5	2.3	3.6	1.8
Тайшир	Taishir	20.2	21.6	17.2	22.6	30.1	2.5	1	0.5	2.2	3.1
Тонхил	Tonkhil		0	0	0	0.0	4.1	3	3	3.8	3.0
Төгрөг	Tugrug	14	5.5	3.5	5	10.0	3.5	5	6.7	2	2.0
Халиун	Khaliun	72	35.6	7	8.5	5.8	40	21	6.3	7.1	45.5
Хөхморьт	Khukhmorit	0.5	0	0	0	0.0	0.2	0.5	0.2	0.1	0.2
Цогт	Tsogt	3	276	171	218	25.0	3.2	7	8	7	8.0
Цээл	Tseel		0	0	0	0.0	8	1	2.1	5.8	5.2
Чандмань	Chandmani	104	115	104.4	110	97.0	35	6	8.1	5.5	8.0
Шарга	Sharga	15	20	10	60	50.0	20	15	6.5	10	10.0
Эрдэнэ	Erdene		0	0	0	0.0	1	0.3	1.2	3	2.0

Хураасан ургац, бэлтгэсэн өвс хадлан жил бүрийн эцэст



ТАРИАЛСАН ТАЛБАЙ, ургамлын төрлөөр, сумаар
SOWN AREAS, by types of plants, soums

Сум	Soum	Хүнсний ногоо, га / Vegetables, hectar					Тэжээлийн ургамал, га / Fodder crops, hectar				
		2013	2014	2015	2016	2017	2013	2014	2015	2016	2017
Бүгд	Total	124.1	71.9	77.9	90.2	117.8	543.7	415.3	398	481.5	683
Есөнбулаг	Yesunbulag	13.9	14.2	18.8	14.8	18.4	20.2	21	8.7	9.2	11.3
Алтай	Altai	2.2	1.4	0.8	0.3	0.8	2	1	0.4	5	0.5
Баян-Уул	Bayanuul	0.5	0.1	0.1	0	0.0		0	1.3	4	0
Бигэр	Biger	1.8	4.7	0.5	1.4	1.0	95.3	99.3	117	115	114.3
Бугат	Bugat	4	5.2	5.1	2	3.8	97.5	80	80	100	100
Дарив	Darib	1	0.5	0.2	0.5	0.5	4	0	0.6	1.1	0.06
Дэлгэр	Delger	24.2	14.1	15.5	24.6	7.1	8	5	7	10	5
Жаргалан	Jargalan	2.1	2.4	1.9	2.5	2.3	20	30	15	2.4	14.6
Тайшир	Taishir	1.3	0.8	0.5	1.5	0.5	85	85.5	0	86.5	86
Тонхил	Tonkhil	0.8	0.8	1.2	1.5	1.1		0	0	0.2	0
Төгрөг	Tugrug	6.3	3	4	1.8	1.7	9.7	7.5	16	2.5	7
Халиун	Khaliun	36.5	4	13.7	12.2	20.0	68	13	8	8.1	11
Хөхморьт	Khukhmorit	1.8	1.5	0	0.1	0.3	1	0	1	0	0
Цогт	Tsogt	0.8	4	8.8	14	49.0		0	52	20	165
Цээл	Tseel	0.6	0	0	3.4	2.7		4	1	30	30.2
Чандмань	Chandmani	9.2	5	3.3	3.5	1.6	131	67	88	85.5	133
Шарга	Sharga	17	10	3.5	5	6.0	2	2	2	2	5
Эрдэнэ	Erdene	0.1	0.2	0	1	1.0		0	0	0	0

ХУРААСАН УРГАЦ , ургамлын төрлөөр, сумаар
TOTAL CROPS , by types of plants, soums

Сум	Soum	Үр тариа, тн / Cereals, t					Төмс, тн / Potatoes, t				
		2013	2014	2015	2016	2017	2013	2014	2015	2016	2017
Бүгд	Total	332.4	475.4	514.1	525.3	324.1	1013	510.	652.	633.	831.
Есөнбулаг	Yesunbulag	15.6	14.5	56	20.7	43.6	145	136.	136.	162	118.
Алтай	Altai		0	0			6.5	11.5	2.1	8	12.9
Баян-Уул	Bayanuul		0	0			2	2.8	5.1	8.3	2.3
Бигэр	Biger	3	4.4	6.9	2.64	1.5	15	22.5	5.4	8.8	7.5
Бугат	Bugat	2.8	4.1	5.5	1	6.0	64.7	16.3	130	35	30.0
Дарив	Darib	3	2	0.7	0.07	3.5	4.5	1.5	2.4	0.75	2.5
Дэлгэр	Delger	3.7	1.3	0		0.0	62.3	14	15.6	24.4	6.2
Жаргалан	Jargalan		2.3	2	3		7.4	6.1	9.3	25.2	8.0
Тайшир	Taishir	33.7	17.4	13.7	30.4	34.5	8	6	2	16	56.6
Тонхил	Tonkhil		0	0			3.5	10	10.5	17.5	9.0
Төгрөг	Tugrug	7	4	4.2	7	13.5	20	24	46.9	24	18.1
Халиун	Khaliun	90	5.7	11.5	10.5	6.0	292	40.1	50.4	60	326.
Хөхморьт	Khukhmorit	1.2	0	0			3	1	0.7	1.5	0.6
Цогт	Tsogt	3.8	245	180	190	20.0	20	25	30	51	60.0
Цээл	Tseel		0	0			18	5	1.4	19.3	22.7
Чандмань	Chandmani	158.6	172.5	231.6	122	145.5	210	90	122	52.3	52.3
Шарга	Sharga	10	2.2	2	138	50.0	130	97.5	78	95	95.0
Эрдэнэ	Erdene		0	0			1	0.5	4.5	24	3.0

ХУРААСАН УРГАЦ , ургамлын төрлөөр, сумаар
TOTAL CROPS , by types of plants, soums

Сум	Soum	Хүнсний ногоо, тн / Vegetables, t					Тэжээлийн ургамал, тн / Fodder crops, t				
		2013	2014	2015	2016	2017	2013	2014	2015	2016	2017
Бүгд	Total	619.	336.	386.	468.	371.1	1214	1049	1159	1479	1577
Есөнбулаг	Yesunbulag	90.4	88	102.	101.	74.9	68.7	71.4	45	48.1	67.8
Алтай	Altai	4.4	8.1	0.8	3.9	4.8		0	0	6.5	1.5
Баян-Уул	Bayanuul	0.8	1.8	0.9		0.7		0	30	20	
Бигэр	Biger	1.2	11	7.4	4.1	1.7	147.5	354.7	390	486.5	126.6
Бугат	Bugat	4.4	11.3	38.5	12.3	30.4	348	344	330	229.5	60
Дарив	Darib	2.7	0.9	0.2	0.8	0.9	25	0	0.8	0.11	1
Дэлгэр	Delger	147.			83.7	14.3					5
Дэлгэр	Delger	7	47.7	15.1	4		7	5.5	11.5	22	
Жаргалан	Jargalan	4.4	4	4.4	3.95	8.8	16	19.3	30	40	17.5
Тайшир	Taishir	3.7	2.4	1.2	7.35	0.8	50	0	0	115	90
Тонхил	Tonkhil	4.6	4.8	5	5.5	3.6		0	0	0.5	
Төгрөг	Tugrug	24	12.4	34.3	26.5	15.0	18	6.5	8	2	12
Халиун	Khaliun	200	22.8	65	54.9	75.3	200	5	6	105	32.1
Хөхморьт	Khukhmorit	2.5	2	0.9	1.7	2.8		0	2		
Цогт	Tsogt	3.7	13	30	75.3	40.8		0	23	10	150
Цээл	Tseel	5.3	0	0.1	18.0	16.9		2	19	2.3	62.8
Цээл	Tseel				5						

Чандмань	<i>Chandmani</i>	59.8	59.5	51.5	28.3	8.3	327.5	234.5	264	376.5	931
Шарга	<i>Sharga</i>	60	47	28.2	35	70.0	6	6	0	15	20
Эрдэнэ	<i>Erdene</i>		0.2	0	6	1.0		0	0		

Намрын ургац хураалтаар 324.1 тн үр тариа, 831.4 тн төмс, 371.1 тн хүнсний ногоо, 2577 тн тэжээлийн ургамал тус тус хураан авчээ.

Дүгнэлт

Говь-Алтай аймаг 2017 оны жилийн эцсийн мал тооллогоор 3801.7 мянган толгой мал тоологдсоны дотор адуу 123.7 мянган толгой, үхэр 85.4 мянган толгой, тэмээ 42.0 мянган толгой, хонь 1194.6 мянган толгой, ямаа 2356.0 мянган толгой мал тус тус тоологджээ.

Малын нийт тоо өмнөх оноос 304.2 мянга буюу 8.7 хувиар өссөний дотор адуу 16.8 мянга буюу 15.8 хувь, үхэр 14.3 мянга буюу 20.2 хувь, тэмээ 3.4 мянга буюу 8.9 хувь, хонь 87.5 мянга буюу 7.9 хувь, ямаа 182.1 мянга буюу 8.4 хувиар тус тус өсчээ. Улсад нийт тэмээ болон ямааны тоогоор 3-р байранд, нийт малын тоогоор 7-р байранд тус тус орсон байна.

Малтай 10180 өрх байгаагийн 7183 нь малчин өрх байна. Мөн энэ онд 1000 түүнээс дээш малтай өрхийн тоо 746 болж өнгөрсөн оноос 100 өрхөөр нэмэгджээ.

2017 онд малын тоогоор эхний таван байранд Цогт /307.6 мянган толгой/, Дэлгэр /287.9 мянган толгой/, Эрдэнэ /280.4 мянган толгой/, Тонхил /269.9 мянган толгой/, Халиун /247.8 мянган толгой/ сумд тус тус орсон байна.

Адуун сүргийн тоогоор Тонхил, Хөхморьт, Есөнбулаг сум, Баян-Уул, Халиун, үхэр сүргийн тоогоор Бигэр, Есөнбулаг, Цогт, Халиун, Шарга сум, тэмээн сүргийн тоогоор Төгрөг, Шарга, Халиун, Хөхморьт, Цогт сум, хонин сүргийн тоогоор Тонхил, Дэлгэр, Баян-Уул, Чандмань, Цогт сум, ямаан сүргийн тоогоор Эрдэнэ, Цогт, Дэлгэр, Халиун, Цээл сум эхний таван байранд орсон байна.

Мянгат малчдын тоо өмнөх оноос 15.5 хувиар өсч 746 боллоо. Үүний дотор 2001-ээс дээш малтай өрх 30, 1500-2000 малтай өрх 90, 1000-1499 малтай өрх 626 байна

Хээлтэгч мал өмнөх оноос 7.2 хувиар өсч, оны эцсийн байдлаар төллөх насны хээлтэгч 1 сая 514.3 мянга болж, нийт малын 39.8 хувь, тухайн сүргийн дотор гүү 30.0, үнээ 36.7, ингэ 33.4, эм хонь 41.4, эм ямаа 39.8 хувийг тус тус эзэлж байна.

Нийт төллөх насны хээлтэгчийн 94.2 хувь, гүүний 87.2 хувь, үнээний 90.5 хувь, ингэний 52.8 хувь, эм хонины 95.7 хувь, эм ямааны 94.5 хувь нь тус тус төллөсөн байна. Мөн тайлант онд 14.1 мянган хээлтэгч мал хээл хаяж, 92.2 мянган хээлтэгч мал сувайрсан байна.

Энэ оны эцсийн байдлаар үр тариа 324.1 тн, төмс 831.4 тн, хүнсний ногоо 371.1 тн, малын тэжээлийн ургамал 1577 тонныг тус тус хурааж аваад байна..Мөн 1665 тн байгалийн хадлан, 5 тн гар тэжээл, 268 тн хужир шүү тус тус бэлтгэсэн байна.

2017 оны гүйцэтгэлээр манай аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 46.5 хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж байна.

Хөдөө аж ахуйн салбар үүний дотор мал аж ахуйн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн түүхий эдийг нийлүүлж боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, мал аж ахуй болон газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй , баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болдог.

Мал аж ахуйн салбарын хөгжлийг эрчимжүүлэх, мал сүргийн өсөлтөд нөлөөлж буй сөрөг нөлөөг багасгахын тулд малчдын хөдөлмөрийг нэгтгэх, ашиг шим багатай олон тооны мал биш ашиг шим өндөртэй цөөн тооны мал өсгөх, сүргийн бүтцийн зохистой харьцааг хангах, сүү мах, малын гаралтай түүхий эд боловсруулах жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Цаашид залуу малчдын тоо жилээс жилд буурч байгаа үед мал маллагааны арга ажиллагааг залуу үед сургах, суурьшуулах арга хэмжээ шаардлагатай байна.

Мөн нэг асуудал нь орон нутагт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг бэлтгэх төвлөрсөн цэгүүд, хадгалах, хөргөх, агуулах зоорийг бий болгох, сэргээн засварлах асуудал чухал байгаа юм.